



“МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ” ТӨХК-ийн
Гүйцэтгэх захирал

Р.БАТСҮХ



“УЛААНБААТАР БҮК” ХК-ийн
Гүйцэтгэх захирал

Х.ЗОЛЖАРГАЛ

ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ

2020 оны 07 дугаар
сарын 27-ны өдөр

№ ХХат-20/182-149/37 Улаанбаатар хот

Энэхүү Худалдах, худалдан авах гэрээ /Цаашид “Гэрээ” гэх/-г

Нэг талаас: “МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ” төрийн өмчит хувьцаат компани түүнийг төлөөлж Гүйцэтгэх захирал Р.Батсүх (цаашид “Худалдан авагч” гэх),

Нөгөө талаас: Улсын бүртгэлийн гэрчилгээний 9010001027, регистрийн 2041219 дугаартай “Улаанбаатар БҮК” ХК, түүнийг төлөөлж Гүйцэтгэх захирал Х.Золжаргал (цаашид “Худалдагч” гэх)

нар хүсэл, зориг, ашиг сонирхлоо бүрэн илэрхийлж Монгол Улсын Их Хурлын 2010 оны 32-р тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 315 дугаар тушаалаар байгуулагдсан “Дэд ажлын хэсэг”-ийн 2020 оны 05 сарын 29-ний өдрийн хуралдаанаас гарсан 131 дүгээр зөвлөмжийг үндэслэн дараах нөхцөлөөр харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

Энэхүү гэрээ нь сайн дурын үндсэн дээр байгуулагдсан бөгөөд гэрээний бүх зүйл, заалттай нэг бүрчлэн бүрэн танилцаж хүлээн зөвшөөрөгдсөн байх, хүсэл зоригоо бүрэн илэрхийлсэн байх зарчимд тулгуурлагдсан болохыг 2 тал харилцан хүлээн зөвшөөрөв.

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Гэрээний зорилго

1.1.1. Худалдагч нь стандартын дагуу үйлдвэрлэгдэж, чанарын шаардлага хангасан биет байдлын доголдолгүй, эрхийн зөрчилгүй Пандрол маягийн бэхэлгээтэй 1520 мм царгийн Төмөр бетон дэр /цаашид бараа, бүтээгдэхүүн гэх/, түүнтэй холбоотой баримт бичгийн хамт худалдан авагчийн өмчлөлд шилжүүлэх, худалдан авагч нь худалдагчид гэрээнд заасан нөхцөлөөр төлбөр тооцоог гүйцэтгэхтэй холбоотой үүсэх харилцааг зохицуулна.

1.2 Гэрээний хавсралтууд

Дараах бичиг баримтуудыг гэрээнд хавсаргах бөгөөд эдгээр нь энэхүү гэрээний салшгүй хэсэг болно. Үүнд:

- 1.2.1. Худалдан авах бараа бүтээгдэхүүний техникийн тодорхойлолт /Хавсралт 1/;
- 1.2.2. Бараа бүтээгдэхүүний жагсаалт, үйлдвэрлэх, нийлүүлэх хуваарь /Хавсралт 2/;
- 1.2.3. Бүтээгдэхүүний тохирлын гэрчилгээ; /Хавсралт 3/;
- 1.2.4. Тусгай зөвшөөрөл; /Хавсралт 4/;
- 1.2.5. “Монгол Улсын бетон дэр нэгдэл”-д оролцогч компаниудын хооронд байгуулагдсан “Хамтран ажиллах гэрээ” /Хавсралт 5/;
- 1.2.6. Бусад /тухайн худалдах бараа бүтээгдэхүүнээс шалтгаалан бусад хавсралтуудыг нэмж болно. /зураг төсөл г.м/

Хоёр. Гэрээний үнэ, төлбөр төлөх нөхцөл, хэмжээ, хариуцлага

2.1 Гэрээний үнэ, тоо хэмжээ

2.1.1. Нийт 125,497 /нэг зуун хорин таван мянга, дөрвөн зуун ерэн долоо / ширхэг Төмөр бетон дэрийг нийлүүлэх ба бараа бүтээгдэхүүний нэг бүрийн үнэ нь 84.7 /Наян дөрвөн доллар далан цент/ ам доллар байна.

2.1.2. Дээрх үнэд НӨАТ, Зүүнбаян өртөө хүртэлх тээвэрлэлтийн зардал болон бусад зардал орсон болно.

2.1.3. Төлбөр тооцоог төгрөгөөр гүйцэтгэх бөгөөд гадаад материал болох арматур, бэхэлгээ, металл бэлдэц, химийн нэмэлт бүтээгдэхүүний үнэ 38,39 ам долларыг Монгол банкны тухайн өдрийн зарласан албан ханшаар тооцно.

2.1.4. Энэхүү гэрээний 2.1.3-т зааснаас бусад түүхий эд, материал, үйлдвэрлэлийн зардлын үнэ 46,31 ам.долларыг гэрээ байгуулсан өдрийн Монгол банкны албан ханш буюу 1,842.11 төгрөгөөр тогтмол тооцно.

2.1.5. Урьдчилгаа төлбөрийн санхүүжилтийг нийт нийлүүлэгдэх бараа, бүтээгдэхүүний 30 хувьтай тэнцэх хэмжээний буюу 37,649 ширхэг төмөр бетон дэрний нэг бүрийн үнийг Гэрээний 2.1.3, 2.1.4-т заасан зарчмаар төгрөгөөр тооцож олгох бөгөөд Худалдагч уг санхүүжилтийн дүнгээр банкны баталгаа гаргасан байна. Худалдан авагч санхүүжилтийг нэхэмжлэл хүлээн авснаас хойш ажлын 5 өдрийн дотор Худалдагчид олгоно.

2.1.6. Урьдчилгаа төлбөрийн дараагийн 30 хувийн санхүүжилтийг бараа, бүтээгдэхүүний үйлдвэрлэлт 30 хувьд хүрснийг талууд актаар баталгаажуулснаар, түүний дараагийн 30 хувийн санхүүжилтийг бараа бүтээгдэхүүний үйлдвэрлэлт 60 хувьд хүрснийг талууд актаар баталгаажуулсан тохиолдолд тус тус олгох бөгөөд Худалдагч нь санхүүжилт хийгдэх тухай бүрт уг дүнгээр банкны баталгаа гаргасан байна.

2.1.7. Үлдэгдэл 10 хувийн санхүүжилтийг Гэрээний 2.1.1-д заасан бараа, бүтээгдэхүүнийг бүрэн хүлээн авсны дараа олгоно.

2.1.8. Гэрээний төлбөрийг Худалдагчийн Хаан банкны **5003636128** тоот дансанд шилжүүлнэ.

2.1.9. Эцсийн санхүүжилт хийгдэхээс өмнө Худалдагч нь үүргийн гүйцэтгэлийн баталгаа болгон гэрээний нийт үнийн дүнгийн 5 хувьтай тэнцэх хэмжээгээр, баталгаат хугацааг дуусах хүртэл хугацаанд хүчин төгөлдөр банкны баталгаа гаргаж өгнө. Ийнхүү гаргаж өгөөгүй тохиолдолд гүйцэтгэлийн баталгааг уг дүнгээр баталгаат хугацаа дуусах хүртэл Худалдан авагчийн дансанд байршуулна.

2.1.10. Худалдагч нь гэрээнд заасан үзүүлэлт, хугацааны дагуу бараа бүтээгдэхүүнийг нийлүүлэх үүргээ биелүүлээгүй тохиолдолд түүний баталгаа гаргуулсан банкинд шаардлага гаргаж санхүүжилтийн төлбөрийг гаргуулна.

2.2 Хариуцлага

2.2.1 Худалдан авагч нь энэхүү гэрээний дагуу төлбөрийг төлөөгүй тохиолдолд бүтээгдэхүүнийг нийлүүлэхийг шаардах эрхгүй.

2.2.2 Худалдан авагч тал гэрээнд заасан үнийг хугацаанд нь багтаан төлж барагдуулаагүй тохиолдолд хугацаа хэтрүүлсэн хоног тутамд төлөгдөөгүй төлбөрийн үнийн дүнгийн 0,1 хувиар алданги тооцож Худалдагч талд төлнө.

2.2.3 Нийлүүлэгч бараа, бүтээгдэхүүнийг энэхүү гэрээний хавсралт 2-т заасан хугацаанд Захиалагчид нийлүүлээгүй тохиолдолд хугацаа хэтрүүлсэн хоног тутам гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0,1 хувиар алданги тооцож Худалдан авагч талд төлнө.

Гурав. Гэрээний хугацаа, бараа бүтээгдэхүүний доголдол, хүлээн авах, өмчлөх, сав баглаа боодол

3.1. Гэрээний хугацаа

3.1.1. Энэхүү гэрээ нь гэрээ хүчин төгөлдөр болсон өдрөөс 2020 оны 12 дугаар сарын 15-ны өдөр хүртэл хугацаанд хүчин төгөлдөр байна.

3.1.2. Бараа бүтээгдэхүүнийг гэрээний Хавсралт 2-т заасан хугацаанд Худалдагч нь Худалдан авагчид хүлээлгэн өгнө.

3.1.3. Бараа бүтээгдэхүүнийг нийлүүлэх хугацаанд байгалийн гэнэтийн үзэгдэл болон гамшгаас үүдэн гэрээнд заасан хугацаанд нийлүүлэх боломжгүй болсон тохиолдолд Худалдагч Худалдан авагчид энэ тухайгаа урьдчилан бичгээр мэдэгдэж 2 талын хэлэлцээр хийснээр нийлүүлэх хугацааг дахин тохиролцож болно.

3.2. Баталгаат хугацаа

3.2.1. Худалдагч нь бараа бүтээгдэхүүнийг хүлээлгэн өгснөөс хойш 12 сарын баталгаат хугацаа өгч байгаа болно.

3.3. Бараа бүтээгдэхүүний доголдол

Худалдан авагчийг төлөөлж

Худалдагчийг төлөөлж

Энэхүү гэрээ нь байгууллагын нууцад хамаарах мэдээлэл тул өөр бусад этгээдэд хувилж тараах, нийтийн хүртээл болгохыг хориглоно. Энэ шаардлагыг биелүүлээгүй аливаа этгээдэд хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэх болно.

3.3.1. Бараа бүтээгдэхүүнийг хүлээн авснаас хойш болон баталгаат хугацаанд худалдан авсан бараа бүтээгдэхүүнд үйлдвэрийн доголдол илэрвэл Худалдагч нь ажлын 21 хоногийн дотор доголдлыг газар дээр нь арилгах буюу ижил төрлийн өөр шинэ бараа бүтээгдэхүүнээр шууд сольж өгнө.

3.3.2. Доголдлыг арилгаснаас хойш 1 сарын дотор засварласан болон сольсон бараа, бүтээгдэхүүнд энэ төрлийн болон бусад гэмтэл согог, доголдол дахин гарсан тухай Худалдан авагчаас бичгээр мэдэгдэл ирвэл уг доголдлыг Худалдагч шуурхай арилгана.

3.3.3. Бүтээгдэхүүнийг тээвэрлэгдэх эцсийн цэгт буулгах, эцсийн цэгээс зөөвөрлөх нөхцөлд үүссэн гадны нөлөө, механик эвдрэл гэмтлийг Худалдагч хариуцахгүй болно.

3.3.4. Бүтээгдэхүүний доголдлоос үүссэн хохирлыг Худалдагч бүрэн хариуцан барагдуулна.

3.4. Бараа, бүтээгдэхүүн хүлээн авах, хүлээлгэн өгөх

3.4.1. Худалдагч нь бараа бүтээгдэхүүнийг Хавсралт 2-т заасан жагсаалтын дагуу нийлүүлэх ба уг хавсралт нь гэрээний салшгүй хэсэг болно.

3.4.2. Талууд бараа, бүтээгдэхүүнийг акт үйлдэн хүлээн авч, хүлээлгэн өгнө. Энэхүү хүлээн авсан, хүлээлгэн өгсөн акт нь гэрээний салшгүй хэсэг болно.

3.4.3. Бараа, бүтээгдэхүүн хүлээлцсэн актад талуудын эрх бүхий албан тушаалтнууд гарын үсэг зурснаар бараа бүтээгдэхүүнийг хүлээн авсанд тооцно.

3.4.4. Энэхүү гэрээтэй холбогдолтой бүхий баримт бичгийг албан бичгээр хүлээн авна.

3.4.5. Бүтээгдэхүүн нийлүүлэх эцсийн газар нь Дорноговь аймаг, Зүүнбаян төмөр замын Өртөө байна. Худалдан авагч нь Төмөр зам болон авто замаар тээвэрлэгдэж ирсэн бараа бүтээгдэхүүнийг түргэн шуурхай хүлээн авч, буулгах үүрэгтэй.

3.4.6. Худалдан авагч нь бүтээгдэхүүнийг шалгаж, хүлээлцсэн тухай акт үйлдэж хүлээн авах ба хадгалах, хэрэглэх, буулгалтын горимыг чанд сахин энэ тухай Худалдагчаас гаргасан зөвлөмжтэй танилцах үүрэгтэй.

3.5. Өмчлөх эрх

3.5.1. Бараа бүтээгдэхүүнийг актаар хүлээн авч, төлбөрийг бүрэн төлснөөр зөвхөн тухайн бараа бүтээгдэхүүний өмчлөх эрх Худалдан авагчид бүрэн шилжинэ.

3.5.2. Эрсдэл шилжих. Бүтээгдэхүүнийг Худалдан авагчид актаар хүлээлгэн өгснөөр Бүтээгдэхүүнийг өмчлөх эрх болон эрсдэл Худалдан авагч талд шилжинэ.

3.6. Бараа бүтээгдэхүүний сав баглаа боодол, хадгалалт

3.6.1. Худалдагч бараа, бүтээгдэхүүнийг эцсийн цэг хүртэл тээвэрлэх явцад гэмтэх, муудахаас урьдчилан сэргийлэх бэхэлгээ баглаа боодлоор гэрээнд заасны дагуу хангана.

3.6.2. Баглаа боодол нь тээвэрлэлтийн үеийн хатуу нөхцөл, тээвэрлэлт болон ил хадгалалтын үеийн халуун, хүйтэн болон давс, хур тунадас зэргийг хангалттай тэсвэрлэхээр байвал зохино.

3.6.3. Баглаа, боодлын хэмжээ, жинг сонгохдоо барааг хүргэх эцсийн цэгийн алслагдсан байдал, түүнчлэн тээвэрлэлтийн цэг бүрд ачих, буулгах хангалттай төхөөрөмж байгаа эсэх зэрэг хүчин зүйлийг харгалзсан байна.

3.7. Бараа бүтээгдэхүүний стандарт шаардлага

3.7.1. Худалдагч нь энэхүү гэрээний Хавсралт 1-д заасан техникийн тодорхойлолтод заасан шаардлагын дагуу бараа, бүтээгдэхүүнийг нийлүүлнэ. Нийлүүлэгдэх бараа, бүтээгдэхүүн нь техникийн тодорхойлолтод нийцсэн байна.

3.7.2. Худалдан авагч нь гэрээнд холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүсэл нь холбогдох улсын стандартад нийцсэн байна.

Дөрөв. Талуудын эрх, үүрэг

4.1. Худалдагчийн хариуцлага, эрх, үүрэг

4.1.1. Бараа бүтээгдэхүүнийг гэрээнд заасан үзүүлэлтийн дагуу заагдсан хугацаанд, холбогдох баримт бичгийн хамт шилжүүлнэ.

4.1.2. Худалдагч нь бараа бүтээгдэхүүнийг ашиглах дэлгэрэнгүй заавар зөвлөмжийг Монгол хэл дээр бэлтгэж хүлээлгэн өгөх ба шаардлагатай бол сургалт зохион байгуулна.

- 4.1.3. Бараа бүтээгдэхүүнийг Худалдан авагчид хүлээлгэн өгөх хүртэл зориулалт, хэрэглээний шинж чанарыг алдагдуулахгүйгээр хадгалж, хамгаална.
- 4.1.4. Чанарын доголдолгүй холбогдох стандартад нийцсэн бараа бүтээгдэхүүнийг нийлүүлэх үүрэгтэй.
- 4.1.5. Худалдан авагчид нийлүүлсэн бараа бүтээгдэхүүн болон бусад олж авсан мэдээллийг гуравдагч этгээдэд задруулахгүй.
- 4.1.6. Худалдагч нь бараа, бүтээгдэхүүнийг нийлүүлэхдээ гэрээний Хавсралт 2-т заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.
- 4.1.7. Ямар ч тохиолдолд гэрээний үүргийг гуравдагч этгээдэд шилжүүлэхгүй.
- 4.1.8. Худалдагч нь Худалдан авагч гэрээнд заасан хугацаанд төлбөр тооцоогоо барагдуулаагүй тохиолдолд үйлдвэрлэлийг зогсоох эрхтэй бөгөөд үүнээс шалтгаалан үүсэх үр дагавар болон хугацааны хоцрогдлыг хариуцахгүй.
- 4.1.9. Худалдан авагч болон гуравдагч этгээдийн /тээвэрлэгч/ буруутай үйл ажиллагаанаас шалтгаалан бүтээгдэхүүнд учирсан хохирол, хугацааны хоцрогдлыг Худалдагч тал хариуцахгүй.
- 4.1.10. Гэрээний үнийг гэрээнд заасан хугацаанд төлөхийг Худалдан авагчаас шаардах эрхтэй.

4.2. Худалдан авагчийн хариуцлага, эрх, үүрэг

- 4.2.1. Бараа бүтээгдэхүүнийг гэрээнд заасан хугацаанд нийлүүлэхийг шаардах,
- 4.2.2. Бараа бүтээгдэхүүнд үйлдвэрийн доголдол илэрвэл доголдлыг арилгуулах, ижил төрлийн бараагаар солиулах эрхтэй.
- 4.2.3. Худалдан авагч нь бараа, бүтээгдэхүүнийг захиалснаас хойш Худалдагчтай зөвшилцөн барааны нэр төрөл, маркийг солих, өөрчлөхгүй.
- 4.2.4. Бараа бүтээгдэхүүний үнийг гэрээнд заасан хугацаанд шилжүүлэхийг шаардана.
- 4.2.5. Бараа бүтээгдэхүүнийг акт үйлдэн хүлээн авч, буулгах үүрэгтэй.
- 4.2.6. Бараа бүтээгдэхүүнийг Худалдагчтай тохирсон хугацаанд хүлээн авах ба хүлээн авахдаа хүлээн авах эрх бүхий этгээдийн зөвшөөрөл, итгэмжлэлийг Худалдагч талд хүлээлгэн өгнө. Ийнхүү тохирсон хугацаандаа хүлээн аваагүйгээс үүсэх хохирлыг Худалдан авагч хариуцна.
- 4.2.7. Худалдан авагч тал Худалдагч талын хүлээлгэн өгсөн бараа бүтээгдэхүүний хэмжээг заасан зарлагын баримтад гарын үсэг зурж баталгаажуулж өгнө. Бараа бүтээгдэхүүнийг хүлээн авч нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримтыг журмын дагуу үнэн зөв бүрдүүлэн Худалдагч талд нэг хувийг өгнө.

Тав. Бусад зүйл

5.1 Гэрээ цуцлах

- 5.1.1 Гэрээг аль нэг талын санаачилгаар цуцлах тохиолдолд Талууд ажлын 5 өдрийн дотор бичгээр мэдэгдэн, дараах тохиолдолд харилцан тохиролцож цуцална.
- 5.1.1.1. Худалдан авагчийн санаачилгаар цуцлах тохиолдолд:
- а) нийлүүлсэн бүтээгдэхүүний 20-оос дээш хувь нь гэрээнд заасан чанарын шаардлага, бусад үзүүлэлтийг хангаагүй;
 - б) бараа бүтээгдэхүүнийг гэрээнд заасан хугацаанд Захиалагчид удаа дараа нийлүүлээгүй;
 - в) эрх бүхий байгууллагаас төслийн санхүүжилт зогссон, төслийн үйл ажиллагааг зогсоосон.
- 5.1.1.2. Худалдагчийн санаачлагаар цуцлах тохиолдолд:
- а) худалдан авагч төлбөрийг хугацаанд нь удаа дараа төлөөгүй;
 - б) гүйцэтгээгүй үнийн дүнгийн алдангийн хэмжээ нь гүйцэтгээгүй үнийн дүнгийн 50 хувиас хэтэрсэн тохиолдолд.
- 5.1.2 Гэрээг нэг талын санаачлагаар цуцалсан бол Худалдан авагч нь гэрээг цуцлах өдрийг хүртэл Худалдагчийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний үнийг болон гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор урьдчилан бэлтгэсэн түүхий эд, бараа материалын үнийг Худалдагчид төлнө.
- 5.1.3 Энэхүү гэрээний 5.1.2-т заасан төлбөрийг төлснөөр тус бараа бүтээгдэхүүн Худалдан авагчийн өмчлөлд шилжнэ.

5.2. Гэрээний нөхцөлд өөрчлөлт оруулах

Худалдан авагчийг төлөөлж

Худалдагчийг төлөөлж

Энэхүү гэрээ нь байгууллагын нууцад хамаарах мэдээлэл тул өөр бусад этгээдэд хувилж тараах, нийтийн хүртээл болгохыг хориглоно. Энэ шаардлагыг биелүүлээгүй аливаа этгээдэд хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэх болно.

5.2.1. Худалдан авагч Худалдагчид бичгээр мэдэгдэж 2 тал хэлэлцсэний дараагаар тохиролцоонд хүрвэл гэрээний цар хүрээнд багтаан дор дурдсан нэг буюу түүнээс дээш зүйлийн заалтыг өөрчилж болно. Үүнд:

5.2.1.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх бараа, бүтээгдэхүүнийг Худалдан авагчид зориулан тусгайлан үйлдвэрлэсэн байхаар зураг, зураг төсөл, техникийн тодорхойлолтыг өөрчлөх;

5.2.1.2. Тээвэрлэлтийн болон баглаа боодлын хэлбэр;

5.2.1.3. Бараа, бүтээгдэхүүнийг хүргэх газар.

5.3. Баталгаа

5.3.1. Бараа бүтээгдэхүүн нь хамтран өмчлөгчгүй, ямар нэг төлбөрийн барьцаанд байхгүй болно гэдгийг Худалдагч тал баталгаа гаргаж байгаа болно.

5.3.2. Талууд энэхүү гэрээг байгуулах, хэрэгжүүлэхтэй холбогдуулан мөнгөн буюу мөнгөн бус хэлбэрээр шагнал, шан харамж, урамшуулал зэрэг Гэрээнд тусгагдаагүй аливаа төлбөрийг харилцан төлөөгүй болно.

5.3.3. Талууд энэ гэрээнд дурдсан өөрийн эрхийг нөгөө талын бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр гурав дахь ч этгээдэд шилжүүлэн өгч болохгүй.

5.4. Маргаан шийдвэрлэх

5.4.1. Гэрээг Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль, тогтоомжийн хүрээнд байгуулсан бөгөөд түүнд заасны дагуу ойлгож, тайлбарлагдана.

5.4.2. Гэрээнд заагаагүй бусад асуудлыг Монгол Улсын бусад хуулийн дагуу шийдвэрлэнэ.

5.4.3. Гэрээний хугацаанд болон түүнээс хойш үүсэх маргаантай асуудлыг хоёр тал харилцан эв зүйгээр шийдвэрлэхийг эрмэлзэнэ. Тохиролцоонд эс хүрсэн тохиолдолд Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

5.5. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах

5.5.1. Талууд гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах бол нэмэлт өөрчлөлт оруулах тухай саналаа ажлын 5 хоногийн өмнө бичгээр ирүүлнэ.

5.5.2. Нэмэлт өөрчлөлтийг бичгээр хийх бөгөөд талуудын эрх бүхий этгээд гарын үсэг зурж, тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болно.

5.5.3. Нэмэлт өөрчлөлт нь энэ гэрээний салшгүй хэсэг болно.

5.6. Нууцыг хадгалах

5.6.1. Худалдагч талаас өгсөн аливаа нэг мэдээллийн нууцыг гэрээний хугацаа дууссан эсэхээс үл хамааран чанд хадгална.

5.6.2. Талууд нь нөгөө талын зөвшөөрөлгүйгээр гэрээний үүргийг биелүүлэхээс бусад тохиолдолд олшруулах, нийтэд тараах, нийтлэх, задруулах эрхгүй.

5.6.3. Нууц хадгалах үүргээ биелүүлээгүйгээс Худалдагчид ямар нэг хохирол учирсан тохиолдолд хохирлыг үл маргах журмаар худалдан авагч тал нь төлж барагдуулна.

5.7. Давагдашгүй хүчин зүйл

5.7.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдал гэдэгт үерт автах, гал түймэрт нэрвэгдэх, дэлбэрэлтэд өртөх, газар хөдлөх, тахал болон бусад байгалийн хүчин зүйлс мөн цэрэг, дайны үйл ажиллагаа, ажил хаялт зэрэг нь энэ гэрээг зохих ёсоор биелүүлэх боломжгүй байдал бий болохыг ойлгоно.

5.7.2. Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн улмаас талуудын аль нэг нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй бол нөгөө талдаа ажлын 5 хоногийн дотор бичгээр мэдэгдэх ба энэ тохиолдолд үүрэг гүйцэтгэх хугацаа нь энэхүү нөхцөл байдал үргэлжлэх хугацаагаар хойшлогдоно. Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл хуанлийн 30-аас дээш хоногийн хугацаагаар үргэлжилбэл талууд асуудлыг харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэнэ.

5.7.3. Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлыг зохиомлоор буюу болгоомжгүйгээр бий болгосноос бусад тохиолдолд давагдашгүй хүчин зүйлийн нөхцөл байдлаас шалтгаалан учирсан хохирлыг хариуцах үүргээс талууд харилцан чөлөөлөгдөнө.

5.7.4. Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдал үүссэнийг эрх бүхий байгууллага /МҮХАҮТ/ нотолсон байвал зохино.

5.8. Гэрээ хүчин төгөлдөр болох

5.8.1. Энэхүү гэрээ нь Монгол хэл дээр 2 эх хувь байх бөгөөд хоёр талын эрх бүхий этгээдүүд гарын үсэг зурж, дугаар авч, тэмдэг дарж баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.

5.8.2. Гэрээтэй холбогдон гарах аливаа мэдэгдэл, шаардлага, захидлууд нь бичгийн хэлбэрээр байх бөгөөд доорх хаягаар хүргэсэн үед тухайн баримтыг хүлээн авсанд тооцно.

5.8.3. Гэрээ болон түүний хэрэгжилттэй холбоотой бүхий л мэдээлэл, мэдэгдэл, хүсэлтийг талууд дараах албан ёсны хаягаар хүргүүлнэ. Үүнд:

Худалдагч:

Хаяг: УБ хот, БГД, 20-р хороо, “Улаанбаатар БҮК” ХК-ийн өөрийн байр

Утас: 70001182, 70001713

И-мэйл: info@ubbuk.mn

Холбогдох /харьцах/ ажилтан: Эдийн засагч: Г.Буянбат

Утас: 91101523, 90119670

Худалдан авагч:

Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, 13 хороолол /14230/, Нарны зам-62 Юнион бюлдинг А блок 7 давхар

Утас: 7000-6622, 7010-6655

И-мэйл: info@mtz.mn

Холбогдох /харьцах/ албан тушаалтан: Инженер технологийн хэлтсийн дарга

Д.Нямлхагва

Утас: 99116455

ЭНЭХҮҮ ГЭРЭЭНИЙ БҮХ ЗҮЙЛ ЗААЛТТАЙ БҮРЭН ТАНИЛЦАЖ, ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРСӨН
БӨГӨӨД ЯМАР НЭГЭН МАРГААНГҮЙ БОЛОХЫГ БАТЛАВ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН

ХУДАЛДАН АВАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

“МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ” ТӨХК-ийн
Инженер технологийн хэлтсийн дарга



Д.Нямлхагва

ХУДАЛДАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

“Улаанбаатар БҮК” ХК-ийн
Гүйцэтгэх захирал



Х.Золжаргал

“Монголын төмөр зам” ТӨХК-ийн 2020 оны
... сарын ... өдрийн дугаартай
гэрээний хавсралт 1 дүгээр хавсралт

Худалдан авагчийг төлөөлж

Худалдагчийг төлөөлж

Энэхүү гэрээ нь байгууллагын нууцад хамаарах мэдээлэл тул өөр бусад этгээдэд хувилж тараах, нийтийн хүртээл болгохыг хориглоно. Энэ шаардлагыг биелүүлээгүй аливаа этгээдэд хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэх болно.

"Монголын төмөр зам" ТӨХК-ийн 2020 оны
07 сарын 27 өдрийн ХХАТ-аг/182-179/37 дугаартай
гэрээний хавсралт 1 дүгээр хавсралт



ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1. Бараа, бүтээгдэхүүний тодорхойлолт: **Пандрол болон Восслох Маягийн бэхэлгээт 1520 мм төмөр замын бетон дэр**
2. Стандарт, шаардлага: **MNS 4700-99, MNS EN 13230-1.2;2013**
3. Баглаа, боодол: **1*0.05*0.05 ивүүр мод, бэхлэх 4мм төмөр утас**
4. Бусад

Хүлээн зөвшөөрсөн :

ХУДАЛДАН АВАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Инженер, технологийн газрын дарга

Д.Нямлхагва

ХУДАЛДАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

"Улаанбаатар БҮК" ХК-ийн
Гүйцэтгэх захирал



Х.Золжаргал

"Монголын төмөр зам" ТӨХК-ийн 2020 оны
07 сарын 27 өдрийн ДТ/20/188-179/37 дугаартай
гэрээний хавсралт 2 дугаар хавсралт



ТӨМӨР БЕТОН ДЭР НИЙЛҮҮЛЭХ ХУВААРЬ

№	Төмөр бетон дэр нийлүүлэх сар	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Хугацаа
1	2020 оны 09 дүгээр сар	ширхэг	41,225	09 сарын 30-нд
2	2020 оны 10 дугаар сар	ширхэг	42,125	10 сарын 31-нд
3	2020 оны 11 дүгээр сар	ширхэг	42,147	11 сарын 30-нд

Хүлээн зөвшөөрсөн :

ХУДАЛДАН АВАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Инженер, технологийн газрын дарга

Д.Нямлхагва

ХУДАЛДАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

"Улаанбаатар БҮК" ХК-ийн
Гүйцэтгэх захирал



Х.Золжаргал



PC01
MNS ISO/IEC 17065

ТОХИРЛЫН ГЭРЧИЛГЭЭ



БАРИЛГА АРХИТЕКТУР КОРПОРАЦИ

33/18

www.bak.bariiga.mn

000183

Ажлын нэр/байгууллага/иргэн:

“УЛААНБААТАР БУК” ХК
БГДүүрэг 20-р хороо, Дунд голын эрэг,
өөрийн компанийн байранд байрлалтай.
И-мэйл: info@abbuk.mn
у/ф: 70001182/70001317
у: 80113117, 88082193, 99088424

Энэхүү гэрчилгээг олгоход үндэслэсэн баримт бичгүүд:

1. Сорилтын үр дүнгийн дугаар, бгноб:
1640 тоот баталгаажуулалтын сорилт туршилтын үр дүн
2. Сорилт хийсэн лабораторийн нэр
БАРИЛГА АРХИТЕКТУР КОРПОРАЦИЙН СОРИЛТЫН ЛАБОРАТОРИ
3. Удирдлагын тогтолцооны нэр, гэрчилгээний дугаар, олгосон байгууллагын нэр
БАТАЛГААЖУУЛАЛТЫН ЗӨВЛӨЛИЙН 2018.06.29-НЫ ӨДРИЙН ХУРЛЫН ШИЙДВЭР
ҮББЗЗ/18
БАРИЛГА АРХИТЕКТУР КОРПОРАЦИЙН БҮТЭЭГДЭХҮҮН БАТАЛГААЖУУЛАЛТЫН АЛБА

Бүтээгдэхүүн/үйлчилгээний тодорхойлолт:

No	Нэр/Тоо хэмжээ	БТКУС-ийн код:	Стандарт, НТББ-ийн тэмдэгтээ:
	ТӨМӨРЗАМЫН ГОЛ ЗАМ, ӨРТӨӨНЫ ЗАМЫН (SI) ТӨМӨРБЕТОН ДЭР		MNS EN13230-1:2013 MNS EN13230-2:2013

Дээрх бүтээгдэхүүн/үйлчилгээ нь холбогдох стандарт, норматив техникийн баримт бичиг (НТББ)-ийн шаардлагыг хангаж байгаа тул энэхүү ГЭРЧИЛГЭЭ-г олгов.

Баталгаажуулалтын албаны дарга:



Д. Хайсамбуу

Баталгаажуулалтын шинжээч:

Ж. Янжмаа

2018.06.29

Олгосон оглоо

2021.06.29

Дуусах оглоо



МОНГОЛ УЛС
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ

ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ

Дугаар: СБҮ 2/053-2020

Байгууллагын нэр:	“Улаанбаатар бүк” ХК
Улсын бүртгэлийн дугаар:	9010001027
Регистрийн дугаар:	2041219
Байгууллагын хаяг:	Улаанбаатар, Баянгол, 20-р хороо, Дунд гол БГД, өөрийн байранд

Монгол Улсын Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.15.11, Төмөр замын тээврийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.5 дахь заалт, 16 дугаар зүйлийн 16.7 дахь хэсгийг тус тус үндэслэн

ТӨМӨР ЗАМЫН СУУРЬ БҮТЭЦ ҮЙЛДВЭРЛЭХ: ЗАМЫН ДООД БҮТЭЦ ҮЙЛДВЭРЛЭХ /ГҮҮР, УС ЗАЙЛУУЛАХ ХООЛОЙ, УЛ ШОРОО/ тусгай зөвшөөрлийг 2020 оны 04 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн 3 /гурав/-н жилийн хугацаатай олгов.

САЙД

Б.ЭНХ-АМГАЛАН


2020 оны 04 дүгээр сарын 17-ны өдөр

Улаанбаатар хот



PC 01
MNS 450/IBC 17095

ГОХИРЛЫН ГЭРЧИЛГЭЭ



БАРИЛГА АРХИТЕКТУР КОРПОРАЦИ

33/18

www.bak.barilga.mn

000183

Адрес: Улаанбаатар / Өвөрхангай / Өвөрхангай

"УЛААНБААТАР БУЖ" ХК
БТ Дүрэг 20-р хороо, Дундговь илэрэ
сөрийн компанийн байрцаж байршилтай.
И-мэйл: info@abbc.mn
у/ф: 70001182/70001317
у: 80113117, 88082193, 99088424

Энэхүү гэрчилгээг өндөхөд үндэслэн баримт бичгүүд:

1. Сорилтын үр дүнгийн дугаар, олгоо.
1610 тоот баталгаажуулалтын сорилт гуршилтын үр дүн
2. Сорилт хийсэн лабораторийн нэр
БАРИЛГА АРХИТЕКТУР КОРПОРАЦИЙН СОРИЛТЫН ЛАБОРАТОРИ
3. Удирлагын тогтолцооны нэр, гэрчилгээний дугаар, олгосон байгууллагын нэр
**БАТАЛГААЖУУЛАЛТЫН ЗӨВЛӨЛИЙН 2018.06.29-НЫ ӨДРИЙН ХУРЛЫН ШИЙДВЭР
УББЗ/18
БАРИЛГА АРХИТЕКТУР КОРПОРАЦИЙН БҮТЭЭГДЭХҮҮН БАТАЛГААЖУУЛАЛТЫН АЛБА**

Бүтээгдэхүүн/үйлчилгээний тодорхойлолт:

№	Нэр/Төрөлмөж	БКУС-ийн код:	Стандарт (НТББ)-ийн гэрчилгээ
	ТӨМӨР ЗАМЫН ГОЛ ЗАМ, ӨРТӨӨНЫ ЗАМЫН (SL) ТӨМӨРБЕТОН ДЭР		MNS EN13230-1:2013 MNS EN13230-2:2013

Дээрх бүтээгдэхүүн/үйлчилгээ нь холбогдох стандарт, норматив техник зүйлс
баримт бичиг (НТББ)-ийн шаардлагыг хангаж байгаа тул энэхүү
ГЭРЧИЛГЭЭ-г олгов.

Баталгаажуулалтын албаны дарга



Хансамбуу

Баталгаажуулалтын мөнхжээ:

(Signature)

2018.06.29
Огноо
2021.06.24
Дуусгах огноо

ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ

**УЛААНБААТАР ХОТ
2019 ОН 08 САРЫН 13 ӨДӨР**

ГЭРЭЭНИЙ ГАРЧИГ

1. НЭР ТОМЪЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ
2. ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭНИЙ ЗОРИЛГО
3. ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХУГАЦАА
4. ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ
5. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ.....
6. ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ГЭРЭЭНИЙ ЭРХ, ҮҮРЭГ
7. ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ХЭМЖЭЭ, ГҮЙЦЭТГЭЛ
8. БАТАЛГАА БОЛОН ҮҮРЭГ АМЛАЛТ
9. НУУЦ ХАДГАЛАХ
10. ХАМТЫН АЖИЛЛАГААНД ХУУЛИЙН ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙГ НЭМЭХ
11. ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ГЭРЭЭНЭЭС ГАРАХ НӨХЦӨЛ
12. ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭНЭЭС ГАРСНЫ ҮР ДАГАВАР
13. ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ ДУУСГАВАР БОЛГОХ
14. ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА
15. ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ
16. ХУУЛЬ ТОГТООМЖ, МАРГААНЫГ ШИЙДВЭРЛЭХ
17. ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭНД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ
18. ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭНД ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН
АЛБАН ЁСНЫ ХАЯГ
19. БУСАД ЗААЛТ

ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ

Энэхүү хамтран ажиллах гэрээг 2019 оны ... сарын өдөр Монгол улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан хуулийн этгээд болох

1. Дорнод ган хийц ХХК /Регистрийн дугаар: 6095186/
2. Улаанбаатар БҮК ХК /Регистрийн дугаар: 2041219/
3. Мон цемент билдинг материалс ХХК/Регистрийн дугаар: 5106567/
4. Монгол бетон дэр ХХК/Регистрийн дугаар: 5716659/
5. Энэрэл холдинг ХХК /Регистрийн дугаар:2617552/

саналын эрхгүй оролцогч тал;

1. Пондрол /Регистрийн дугаар:...../
2. Боссло /Регистрийн дугаар:...../

нар нь Тавантолгой-зүүнбаян чиглэлд шинээр баригдах 414,6 км төмөр замын бүтээн байгуулалт, цаашид УИХ-ын 32-р тогтоолд тусгагдсан төслүүдийн хэрэгжүүлэгч нарт шаардлагатай байгаа төмөр замын хүчитгэсэн дэр бетон нийлүүлэх ажилд хамтран нэгдсэн эв санаа, үзэл баримтлалтай оролцохоо илэрхийлэн тус төслийг хэрэгжүүлэх болон цаашид хэрэгжүүлэх ажилд хамтран ажиллаж оролцохоор тохиролцов.

Тус гэрээг байгуулснаар дараах зүйлийг үүгээр хүлээн зөвшөөрөв.

1. НЭР ТОМЪЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

1.1.Гэрээнд хэрэглэгдэх нэр томъёог дараах утгаар ойлгоно.

Хамтын ажиллагаа:	Гэрээний оролцогч талуудын хамтын ажиллагааны нэгдлийг;
Хүчин төгөлдөр байдал:	Энэ гэрээнд оролцогч талууд гарын үсэг зурж, баталгаажуулалт хийсэн өдөр .
Төсөл хөтөлбөр:	Тавантолгой-зүүнбаян чиглэлд шинээр баригдах 414,6 км төмөр замын бүтээн байгуулалт, цаашид УИХ-ын 32-р тогтоолд тусгагдсан бусад төслүүд.
Бүтээгдэхүүн:	Хэрэгжүүлэх төслийн хүрээнд нийлүүлэгдэх төмөр замын бетон дэр.
Ажлын багц:	Оролцогч тус бүрд үйлдвэрлэлийн хүчин чадал, нөөцөд тулгуурлан хувиарласан бүтээгдэхүүн

нийлүүлэх ажлын хэмжээ;

Стандарт:

Төмөр замын бетон дэр техникийн шаардлагыг бүрэн хангасан Монгол Улсын MNS EN 13230:1-2:2013 стандарт;

Төслийн төлөөлөгч:

Гэрээний талуудын олонхийн саналаар томилогдсон, төслийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан, захиалагч талтай харилцах харилцаа, оролцох оролцоог хариуцан, гэрээний талуудын эрх, ашиг сонирхлыг төлөөлөн оролцох, мэдээлэх үүрэг бүхий этгээд;

Оролцогч тал:

Хамтран ажиллах гэрээ байгуулж, бүтээгдэхүүн нийлүүлэх үүрэг хүлээж буй талууд тус бүрийг;

Саналын эрхгүй оролцогч тал:

Хамтын ажиллагааны гэрээний оролцогч тал болж, гэрээгээр хүлээсэн эрх үүргийг хүлээж, хорооны хуралд саналын эрхгүй оролцох оролцогч этгээд;

Нууцлалын мэдээлэл:

Нууц мэдээлэл гэж байгууллагын нууцын тухай хуулийн дагуу нууц гэж тодорхойлсон, төслийг хэрэгжүүлэх зорилгоор олж мэдсэн эзэмшиж, ашиглаж байгаа баримт бичиг, мэдээ мэдээлэл, энэхүү гэрээнд заасны дагуу үүссэн талуудын ашиг сонирхолд шууд болон шууд бусаар нөлөөлөх бүртгэл, тайлан баримт бичиг, материалыг ойлгоно.

Хувь этгээд:

Гэрээний аль нэг тал дангаар орших хуулийн этгээд, тэдгээрийг төлөөлөх захирал, төлөөлөгч, ажилтан, хамтран ажиллах болон хамтран ажилласан хувь хүн, хуулийн этгээд.

1.2.Хамтран ажиллах гэрээнд томъёологдсон тодорхойлолтууд нь зөвхөн лавлагааны зорилгоор хэрэглэгдэх бөгөөд эдгээр нь холбогдох хуулийн зүйл заалтын утга учрыг илтгэхгүй.

2. ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭНИЙ ЗОРИЛГО

2.1. Нэгдсэн бодлоготойгоор бүтээн байгуулалт, төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ:

- Хамтын ажиллагааны ажлын зохион байгуулалт, талуудын эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлж, хамтын эв нэгдлийг эрхэмлэн, нэгнээ дэмжин ажиллах,
- Хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрийн биелэлтийг бүрэн хангаж ажиллах,

3. ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХУГАЦАА

- 3.1. Хамтран ажиллах гэрээний ерөнхий хугацаа нь гэрээ хүчин төгөлдөр болох өдрөөс эхэлж, хамтын ажиллагааны хорооны хурлын шийдвэрээр дуусгавар болгох өдөр хүртэлх хугацаагаар тодорхойлогдоно.
- 3.2. Хамтын ажиллагааны гэрээний тусгай хугацаа нь аливаа нэгэн төсөл хөтөлбөрт оролцож эхлэх өмнөх аль ч үеэс, тухайн төсөл хөтөлбөрийн дуусгавар болгох хүртэлх болон талуудын бичгээр тохиролцсоноор шаардлагатай гэж үзсэн хугацаа болно.

4. ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

4.1. ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХОРОО

- 4.1.1. Гэрээний талуудын хамтын ажиллагааны хороо нь гэрээний аль нэг талын эрх, ашиг сонирхлыг хөндөхгүйгээр, давуу байдлыг олгохгүйгээр гэрээний талуудын эрх, тэгш байдлын үндсэн дээр хамтын ажиллагааг тогтвортой байлган, төсөл хөтөлбөрүүдэд хамтран ажиллах, хамтын ажиллагаанд хяналт тавих, хамтын ажиллагааны гэрээний хэрэгжилтийг ханган ажиллах зорилго бүхий хороо болно.
- 4.1.2. Талууд энэхүү гэрээнд гарын үсэг зурснаас хойш хуанлийн 5 хоногийн дотор оролцогч тал тус бүрээс нэг төлөөлөгчөөс бүрдсэн хамтын ажиллагааны хороог /цаашид “хороо” гэх/ байгуулна.
- 4.1.3. Хамтын ажиллагааны хороонд саналын эрхгүй хоёроос илүүгүй оролцогч талыг оролцуулж болно.
- 4.1.4. Хамтын ажиллагааны хороогоор шийдвэрлэх асуудлыг оролцогч талуудын албан бичгээр ирүүлсэн саналыг үндэслэн урьдчилан тодорхойлж, Төслийн төлөөлөгч нь хорооны хурал хуралдах товыг урьдчилан оролцогч талуудад гэрээнд тусгасан утас, мэйл хаяг, албан тоотоор мэдэгдсэн байна.
- 4.1.5. Оролцогч талууд хамтын ажиллагааны хорооны хурлын товлосон хугацаанд хүрэлцэн ирж хуралд оролцох үүрэгтэй.
- 4.1.6. Оролцогч талууд нь тогтоосон хугацаанд хуралд хүрэлцэн ирээгүй тохиолдолд хороо хуралдалгүйгээр дахин хурлын товыг 4.1.4-д заасны дагуу дахин зарлана.
- 4.1.7. Оролцогч талууд нь 4.1.6-д заасны дагуу хуралд хүрэлцэн ирээгүй бол хамтын ажиллагааны хороо хуралдана. Хуралд хүрэлцэн ирээгүй оролцогч талын саналыг хорооны хурлаас гарсан шийдвэрийг дэмжсэнд тооцно.

- 4.1.8. Оролцогч тал хуралд биечлэн оролцолгүйгээр гэрээний 4.1.4, 4.1.6-д заасны дагуу хурлын товыг хүлээн авснаас хойш саналаа бичгээр гаргаж болно.
- 4.1.9. Хамтын ажиллагааны гэрээний оролцогч тал тус бүр хорооны хуралд нэг саналын эрхтэй бөгөөд хамтын ажиллагааны хорооны аль ч хуралд оролцох эрхтэй.
- 4.1.10. Хамтын ажиллагааны хорооны хуралд оролцогч тус бүр итгэмжлэн төлөөлөх төлөөлөгчийг томилох эрхтэй ба тус төлөөлөгч нь гэрээний 4.1.9-д заасан эрхийг эдэлнэ.
- 4.1.11. Хорооны шийдвэрийг оролцогчдийн олонхийн саналаар шийдвэрлэнэ. Хорооны шийдвэрт оролцогч талууд тамга дарж баталгаажуулсан байна.
- 4.1.12. Хамтын ажиллагааны хороо нь оролцох болон оролцож буй төсөл, хөтөлбөрүүдэд гэрээ байгуулахаас өмнө болон бусад тал бүрийн урьдчилсан тохиролцоог эрж хайж, олж авах бүхий л боломжийн алхмуудыг хийх хамтын ажиллагааг хангаж ажиллана.

4.2. ТӨСЛИЙН ТӨЛӨӨЛӨГЧ

- 4.2.1. Хамтын ажиллагааны хорооны хурлаар гэрээний оролцогч талуудын олонхийн санал авсан хуулийн этгээдийн төлөөллийг Төслийн төлөөлөгчөөр томилогдох ба тус төслийн төлөөлөгч нь хамтын ажиллагааны үйл ажиллагааг удирдан, хамтын ажиллагааны хорооны хурлаас гарсан шийдвэрт үндэслэн захиалагч талтай харилцах харилцаа, оролцох оролцоог хариуцан, гэрээний оролцогч талуудын эрх, ашиг сонирхлыг төлөөлөн оролцох, мэдээлэх үүргийг тус тус хүлээж ажиллана.
- 4.2.2. Төслийн төлөөлөгч нь хурлыг хэдийд ч зарлан хуралдуулж, шаардлагатай, яаралтай нөхцөл байдлын үед аливаа оролцогч талын бичгээр, цахимаар хүсэлт гаргаснаар хорооны хурлыг хуралдуулна.
- 4.2.3. Төслийн төлөөлөгч нь хуралдааны тэмдэглэлийг гаргаж, шийдвэрийг бичгээр албан ёсоор баталгаажуулж, бүх оролцогч талуудад цаг алдалгүй хүргүүлнэ.

5. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ

- 5.1. Оролцогч талууд нь хамтын ажиллагааны хүрээнд гарсан зардлыг тухай бүр нь тэнцүү хэмжээгээр хариуцан төлнө. Гаргах зардлыг хамтын ажиллагааны хороогоор шийдвэрлэж, Төслийн төлөөлөгч зохион байгуулж ажиллана.

6. ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ГЭРЭЭНИЙ ЭРХ, ҮҮРЭГ

- 6.1. Оролцогч талууд хамтын ажиллагааны хороо болон энэхүү гэрээ, аливаа төсөл, хөтөлбөрийн дагуу хүлээсэн үүрэг бусад бүх үүргээ цаг тухайд нь биелүүлэх үүргийг тус бүр хүлээнэ.
- 6.2. Гэрээний оролцогч талууд гэрээнд заасан зорилго, эрх үүрэг, аливаа төсөл хөтөлбөрийн дагуу байгуулсан гэрээний дагуу хүлээсэн үүрэг биелүүлэх үүднээс

шаардлагатай бүх мэдээлэл, баримт бичгийг Төслийн төлөөлөгчид нэн даруй гаргаж өгөх үүрэгтэй.

6.3. Гэрээний оролцогч тал бүр аливаа оролцогч талаас гэрээний үүргээ зохих ёсоор биелүүлэхийг шаардах эрхтэй.

6.4. Гэрээний талууд харилцан нэгнийхээ өмнө дараах үүргийг хүлээнэ.

6.4.1. Аль нэг оролцогч тал нь энэхүү гэрээ болон захиалагчтай байгуулсан гэрээгээр хүлээсэн үүргийг биелүүлэхтэй холбоотой учирч болох аливаа саатал, гарсан зөрчил дутагдлын талаар бусад оролцогч талуудад мэдэгдэх;

6.4.2. Төсөлтэй холбогдуулан гуравдагч этгээдээс хүлээн авсан холбогдох мэдээллийг бусад оролцогч талуудад мэдэгдэх;

6.4.3. Оролцогч талууд энэхүү гэрээний хүрээнд олж авсан, хангагдсан аливаа мэдээлэл, материалын үнэн зөв байдлыг хангахын тулд бүх нөөц боломжийг гарган ажиллах ба хамтын ажиллагааны хорооноос гаргасан шийдвэрийг биелүүлэх, гаргасан зөрчил дутагдлыг яаралтай засч залруулах үүргийг хүлээнэ.

6.4.4. Оролцогч талууд урьдчилан хорооноос зөвшөөрөл авалгүйгээр хамтын үйл ажиллагаатай холбоотой асуудлаар ямар нэгэн хэвлэл, мэдээлэл, сурталчилгааны бусад материал гаргахыг хориглоно.

6.4.5. Саналын эрхгүй оролцогч тал нь хамтын ажиллагааны хүрээнд оролцож буй оролцоогоор гэрээний нөхцөл, болзол зүйл заалтыг биелүүлэх үүрэгтэй.

7. ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ХЭМЖЭЭ, ГҮЙЦЭТГЭЛ

7.1. Нийлүүлэх ажлын хэмжээ: Захиалагчтай байгуулах гэрээний дагуу нийлүүлэх бетон дэрний тоо хэмжээг гэрээний дагуу тодорхойлох ба оролцогч талуудын бетон дэр үйлдвэрлэлийн хүчин чадал, нөөцөд тулгуурлан нийлүүлэх бүтээгдэхүүний тоог хуваарилан хамтран ажиллах хорооны хурлаар хэлэлцэн баталж байна. Нийлүүлэх бүтээгдэхүүний хэмжээг энэхүү гэрээний хавсралтаар тогтооно.

7.2. Эхний ээлжид захиалагч талд нийлүүлэх бүтээгдэхүүн нь тухайн оролцогч талуудын 2020 оны 06-р сарын 01 ны өдөр хүртэлх үйлдвэрлэлийн хүчин чадалд суурилсан тоо хэмжээ байна.

7.3. Хамтын ажиллагааны хүрээнд гэрээний 7.2-д заасан хугацаанаас хойш нийлүүлэх бүтээгдэхүүны тоо хэмжээг оролцогч талуудын үйлдвэрлэлийн хүчин чадалд суурилож тухай бүр нь хамтын ажиллагааны хороогоор тогтоож байна.

- 7.4. Оролцогч талууд хуваарилагдсан тоо хэмжээ, стандарт шаардлага бүхий бүтээгдэхүүнийг захиалагчтай байгуулах гэрээнд заасан хугацаанд бүрэн нийлүүлж байна.
- 7.5. Гэрээний оролцогч талууд нь эхний ээлжинд ханган нийлүүлэх бүтээгдэхүүний үнийг Зүүнбаян хүргэж өгөх нөхцөлөөр /бэхэлгээний иж бүрдлийн хамт/ нэгдсэн нэг үнээр нийлүүлнэ. Хамтын ажиллагааны хугацаанд нийлүүлэх бетон дэрний үнэ нь нэгдсэн нэг үнэ байна.
- 7.6. Оролцогч талууд нь захиалагч талтай төмөр замын бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээг тус тусдаа байгуулж байна.
- 7.7. Хэрэв аль нэг оролцогч тал нь захиалагч талтай байгуулах гэрээний дагуу бүтээгдэхүүнийг нийлүүлэх боломжгүй, хугацаа хоцрох нөхцөл байдал үүсэх бол нийлүүлэх хугацаанаас 30 хоногийн өмнө урьдчилан хамтын ажиллагааны хороонд мэдэгдэнэ. Хороо тухайн үүссэн нөхцөл байдлыг олонхийн саналаар шийдвэрлэнэ.
- 7.8. Төмөр замын бетон дэр нийлүүлэх гэрээний санхүүжилт, төлбөрийг оролцогч тал тус бүр захиалагч талтай байгуулах гэрээнд тусдаа тооцоо нийлж, төлбөр тооцоог нэхэмжлэхээр тусгаж, гэрээний урьдчилгаа болон нийт үнийн дүнг зориулалтын бусаар зарцуулахгүй байхаа санал нэгтгэе илэрхийлж байна.
- 7.9. Энэхүү гэрээ болон захиалагчтай байгуулах бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээгээр хүлээсэн үүргийг гуравдагч этгээдэд бүхэлд нь шилжүүлэхийг хориглоно. Зөрчсөн тохиолдолд ноцтой зөрчил гэж үзнэ.

8. БАТАЛГАА БОЛОН ҮҮРЭГ АМЛАЛТ

- 8.1 Гэрээний талууд нь Монгол улсын хуулийн дагуу байгуулагдсан, идэвхтэй үйл ажиллагаа эрхэлж буй төлбөрийн чадвартай хуулийн этгээд мөн болно.
- 8.2 Гэрээний талууд нь гэрээнд заасан үүрэг даалгавар, ажлын багцыг биелүүлээгүй буюу тухайн оролцогч талын аль нэг нь үйл ажиллагааны дутагдлын улмаас үүссэн үр дагаврыг хүлээн зөвшөөрч, хорооны хурлаар шийдвэрлэсэн шийдвэрийг биелүүлэн, захиалагчтай байгуулах гэрээнд өмнө хариуцлага хүлээнэ гэдгээ хүлээн зөвшөөрч байгаа болно.
- 8.3 Бүтээгдэхүүн үйлдвэрлэл, үйл ажиллагаатай холбоотой холбогдох хууль тогтоомж, хууль тогтоомж, дүрэм журам, практикийн дүрмийг мөрдөж ажиллана.
- 8.4 Гэрээний оролцогч талууд нь нийлүүлж буй ажлын багцын хэмжээнд нийцүүлэн эрсдэлийн даатгалыг хийлгэсэн байна. Үр дагаврыг бүрэн хариуцна.
- 8.5 Гэрээний оролцогч талуудын аль нэг оролцогч талын эсрэг аливаа шүүх, арбитрагийн шийдвэр гараагүй бөгөөд гэрээнд заасан нөхцөлүүдийг хэрэгжүүлэхэд хүчингүй болгох,

хойшлуулах үйл ажиллагаа гэрээний оролцогч талуудын эсрэг хийгдээгүй түүнчлэн захиалагчийн эсрэг дээрх ажиллагаа хийгдэж эхлээгүй болно.

- 8.6 Бүтээгдэхүүн нийлүүлэх бизнесийн үйл ажиллагаа явуулахад шаардлагатай бүх лиценз, зөвшөөрлийг хууль тогтоомжийн дагуу авах, тэдгээр зөвшөөрөл, лиценз нь хүчин төгөлдөр үйлчилнэ.
- 8.7 Гэрээний оролцогч талууд нь эрх үүрэг, ажлын багцыг зохих ёсоор биелүүлэхэд шаардагдах бүх тоног төхөөрөмж, үйлдвэрлэл, үйлчилгээг бүрэн хариуцах бөгөөд эдгээр нь бүхэлдээ тухайн оролцогч талын өөрийн зардлаар хийгдэнэ.
- 8.8 Энэхүү гэрээний бүх нөхцөл, болзол, зүйл заалтыг зохих ёсоор биелүүлнэ.

9. НУУЦ ХАДГАЛАХ

9.1. Гэрээний талууд, тэдгээрийн ажилтан, удирдлага, туслан гүйцэтгэгч нар нь нууц гэж тодорхойлсон энэхүү гэрээ болон бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээний эрх, үүрэгт заасан мэдээлэл нь нууц байна. Нууц мэдээлэлд:

9.1.1. Гэрээ болон бусад талуудын бизнесийн үйл ажиллагаатай холбоотой нууц гэж тодорхойлсон мэдээллийг; /амаар болон бичгээр мэдсэн/

9.1.2. Төслийг хэрэгжүүлэх зорилгоор олж мэдсэн эзэмшиж, ашиглаж байгаа баримт бичиг, мэдээ мэдээлэл, энэхүү гэрээнд заасны дагуу үүссэн талуудын ашиг сонирхолд шууд болон шууд бусаар нөлөөлөх бүртгэл, тайлан баримт бичиг, материалыг;

9.2. Төслийг хэрэгжүүлэх, үнэлэх ажилд оролцсон ажилчид, төлөөлөгчийн мэдэж байгаа нууц мэдээллийг талуудын урьдчилан бичгээр гаргасан зөвшөөрөлгүйгээр бусдад гуравдагч этгээдэд хэсэгчлэн болон бүхэлд нь задруулахгүй байх үүрэгтэй.

9.3. Нууц мэдээллийг зөвхөн гэрээний талууд төслийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан ашиглах ба өөр өөрийн болон бусад гуравдагч этгээдийн ашиг тусын тулд нууц мэдээллийг өөр хэлбэрээр ашиглахгүй байх үүрэгтэй.

9.4. Талуудын тус бүрийн холбогдох ажилтнууд, төлөөлөгчид гэрээний мэдээллийн нууцлал, нууцлалыг хадгалах эдгээр ажилтан, төлөөлөгч, ажилчдын дагаж мөрдөх нөхцөлийг хангах үүднээс нууцлалын талаар мэдээлэх үүрэгтэй.

9.5. Гэрээ байгуулахаас өмнө аль нэг оролцогч талд хадгалагдаж байсан мэдээлэл, нууц хадгалуулагчаас нийтийн хүртээл болсон, оролцогч талуудын бичгээр өгсөн зөвшөөрлөөр задруулсан мэдээллийг нууцлах үүрэг хүлээхгүй.

9.6. Гэрээний оролцогч талууд нууц гэж тодорхойлсон мэдээллийг задруулсан эсэх талаар нэг нэгэндээ хяналт тавих ба задруулсан тохиолдолд ноцтой зөрчил гэж үзэн энэхүү гэрээ, хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэнэ.

9.7. Өөрийн хүсэлт болон ноцтой зөрчлийн улмаас хамтран ажиллах гэрээнээс аль нэг оролцогч тал нь гарсан бол гарсан оролцогч тал нь гарсан хугацаанаас хойш 5 жилийн

хугацаанд хамтын ажиллагааны хүрээнд олж авсан нууц мэдээ, мэдээллийн нууцлалыг хадгална.

- 9.8. Хамтын ажиллагааны оролцогч талууд гэрээний 13-р зүйлийн дагуу хамтын ажиллагааг дуусгавар болсон өдрөөс хойш 5 жилийн хугацаанд олж авсан нууц мэдээ, мэдээллийн нууцлалыг хадгална.

10. ХАМТЫН АЖИЛЛАГААНД ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙГ НЭМЭХ

- 10.1. Тус хамтран ажиллах гэрээнд гэрээний нэг тал болон оролцож буй төлөөлөгчийн олонхийн санал авсан, бичгээр баталгаажуулсны үндсэн дээр энэхүү гэрээний бүх нөхцөл, зүйл заалтыг хүлээн зөвшөөрсөн Монгол улсын хуулийн дагуу байгуулагдсан хуулийн этгээд нэгдэнэ. Хамтран ажиллах гэрээнд шинээр оролцох хуулийн этгээд гэрээнд нэмэлт өөрчлөлтийн гэрээгээр гарын үсэг зурж баталгаажуулснаар гэрээний оролцогч тал болно.

11. ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ГЭРЭЭНЭЭС ГАРАХ НӨХЦӨЛ

- 11.1. Оролцогч талуудад хохирол учруулахгүйгээр, хамтын ажиллагааг хариуцлагатай, хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрийг биелэлтийг хангаж ажиллах үүднээс дараах тохиолдолд гэрээний үүргээ биелүүлээгүй ноцтой зөрчил гэж үзэн ноцтой зөрчил гаргасан оролцогч талыг хамтын ажиллагаанаас хорооны хурлаар хэлэлцэн шийдвэрлэж олонхийн саналаар гэрээнээс татгалзан гаргана.

11.1.1. Гэрээний хамтын ажиллагаанд нөлөөлөхүйц энэхүү гэрээ болон бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээний үүргийг биелүүлээгүй зөрчсөн бөгөөд хэрэв зөрчлийг арилгах боломжит хугацаа өгсөн боловч тогтоосон хугацаанд зөрчил дутагдлыг арилгаагүй тохиолдолд;

11.1.2. Төсөл, хөтөлбөрийн дагуу хариуцсан багцын ажлыг гүйцэтгэх чадамжгүй болох нь хамтын ажиллагааны явцад үйл баримтаар тогтоогдсон;

11.1.3. Энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхээс татгалзсан, хорооны шийдвэрийг биелүүлээгүй, эсхүл аливаа хамтын ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбоотой хууль бус үйлдэл гаргасан.

11.1.4. Хамтын ажиллагааны гэрээний зорилгыг хэрэгжүүлэх үйлдвэрлэл эрхлэх техник эдийн засгийн нөхцөл байдлаас шалтгаалан зогсоосон.

11.1.5. Эрх бүхий байгууллагын шийдвэрийн дагуу бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйл ажиллагааг зогсоосон.

11.1.6. Гэрээний оролцогч талуудад гэрээгээр хүлээсэн үүрэг, үүргээ гүйцэтгэх чадвар, төсөл хөтөлбөртэй холбоотой хохирол учруулахуйц аливаа хуурамч, ташаа мэдээлэл өгсөн;

11.1.7. Энэхүү гэрээний 7.9-д заасны дагуу бусад оролцогчдын зөвшөөрөлгүйгээр бүтээгдэхүүн нийлүүлэх үүргийг гуравдагч этгээдэд шилжүүлсэн.

11.1.8. Гэрээний зорилгыг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор гэрээний аль нэг тал болон гэрээт гүйцэтгэгчид, ажилчид, агентууд, үйлчлүүлэгчид, бусад бизнесийн түншүүд гэх мэт бусад этгээдүүдийг залилан мэхлэх эсхүл шударга бус үйлдэл гаргасан.

11.2. Аль нэг оролцогч тал нь дараах үндэслэлээр хамтын үйл ажиллагааны гэрээ болон төсөл хөтөлбөрөөс гарах бол хүсэлтээ албан ёсоор бичгээр гаргасны үндсэн дээр хорооны хурлаар зөвхөн санал нэгтгэйгээр гарах эсэхийг шийдвэрлэнэ.

11.2.1. Гэрээний 3.1-д заасан хугацаанд оролцогч аль нэг тал нь хамтын үйл ажиллагаанд хохирол учруулахгүйгээр хэдийд ч гарч болно.

11.2.2. Гэрээний 3.2-д зааснаар тодорхойлогдсон хугацаанд гагцхүү зайлшгүй хүндэтгэх шалтгаанаар хугацаанаас өмнө гарч болно.

11.2.3. Оролцогч талууд нь ноцтой зөрчил гаргаагүй тохиолдолд хамтын ажиллагааны оролцогч тал хэвээр байна.

11.3. Гэрээнээс аль нэг оролцогч тал гарснаар тухайн оролцогч талын хамтын үйл ажиллагаа дуусгавар болно.

12. ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭНЭЭС ГАРСНЫ ҮР ДАГАВАР

12.1. Өөрийн хүсэлт болон ноцтой зөрчлийн улмаас хамтран ажиллах гэрээнээс гарсан бол гарсан оролцогч тал нь хамтын ажиллагааны гэрээний үргэлжлэх хугацаа дуусгавар болох хүрэлх хугацаанд гэрээгээр хүлээсэн эрх, үүргийг биелүүлэх үүргийг хүлээнэ.

12.2. Хамтран ажиллах гэрээнээс гарснаас хойших гарсан оролцогч талын гүйцэтгэвэл зохих ажлын багцыг хорооны хурлаар аль нэг оролцогч болон хэд хэдэн оролцогчдод үйлдвэрлэлийн хүчин чадал, нөөцөд нь тулгуурлан хувиарлан шийдвэрлэж биелүүлэх үүргийг хүлээлгэнэ. Хорооноос гарсан шийдвэрийг оролцогч талууд биелүүлэх үүрэг хүлээнэ.

12.3. Өөрийн хүсэлт болон ноцтой зөрчлийн улмаас гарсан оролцогч тал нь бүтээгдэхүүн нийлүүлэлтийн санхүүжилт, төлбөрийг урьдчилан шилжүүлэн авч захиалагчтай байгуулсан гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол захиалагч тал тухайн асуудлыг /үүргийн зөрчил/ шийдвэрлэх хүртэлх хугацаанд оролцогч талууд дэмжлэг үзүүлж ажиллана.

13. ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ ДУУСГАВАР БОЛГОХ

13.1. Хамтран ажиллах гэрээг дараах үндэслэлээр дуусгавар болгоно.

- Оролцогч талуудын гэрээний 3.1-д заасан ерөнхий хугацааг санал нэгтгэйгээр дуусгавар болгохоор шийдвэрлэсэн.

14. ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА

- 14.1. Энэхүү гэрээнд оролцогч аль нэг тал нь үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүйн улмаас үүссэн хохирлыг нөгөө талдаа төлөх үүрэгтэй. Гэхдээ шууд бус хохирол буюу олох байсан ашгийг нөхөн төлөхгүй.
- 14.2. Аль нэг оролцогч тал нь гэрээгээр зөвшөөрөөгүй хориглосон зүйл заалтыг зөрчсөн тохиолдолд хамтын ажиллагааны хороогоор шийдвэрлэж хариуцлага хүлээлгэнэ.

15. ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ

- 15.1. Гэрээний аль нэг тал давагдашгүй хүчин зүйл / тухайлбал: газар хөдлөлт, үер, гал түймэр, далайн шуурга, хар салхи, халдварт өвчний тархалт болон байгалийн бусад аюулт үзэгдэл, ажил хаялт, оролцоо гэх мэт / -ийн нөхцөл байдлын улмаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд гэрээний хариуцлагаас /алданги, торгууль/ чөлөөлөгдөх үндэслэл болно.
- 15.2. Дээрхи давагдашгүй хүчин зүйл бий болсон тухай нотолгоог тухайн орны Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим гэрчилнэ.

16. ХУУЛЬ ТОГТООМЖ, МАРГААНЫГ ШИЙДВЭРЛЭХ

- 16.1. Хамтран ажиллах гэрээг Иргэний хууль, Байгууллагын нууцын тухай хууль, Компанийн тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу байгуулав.
- 16.2. Хамтран ажиллах гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотой нэг буюу хэд хэдэн оролцогчдын хооронд гарсан маргааныг оролцогчид эвийн журмаар хэлэлцэн хамтран ажиллах хорооны хурлаар шийдвэрлэнэ. Хамтын ажиллагааны хорооны хурлын шийдвэр эцсийн байна.
- 16.3. Оролцогч талууд эвийн журмаар маргааныг хороогоор шийдвэрлэхдээ өөрт байгаа бүхий л үндэслэл бүхий үйл баримтыг гаргаж хүчин чармайлт гарган ажиллана.
- 16.4. Оролцогч талуудын маргааныг зүйлд хөндлөнгийн шинжээч оролцуулж болох ба алдаа, залилан мэхлэх үйлдлээс бусад тохиолдолд шинжээчийн дүгнэлтийг үндэслэн маргааныг зүйлийг шийдвэрлэж болно.
- 16.5. Оролцогч талууд эвийн журмаар шийдвэрлэх боломжгүй энэхүү гэрээтэй холбоотой үүссэн уг гэрээг зөрчих, дуусгавар болгох, хүчингүй болгохтой холбоотой аливаа маргаантай асуудлыг маргаан, зөрүүг Монгол улсын хууль тогтоомжийн дагуу Арбитрын шүүхээр шийдвэрлэнэ.

16.6. Энэ гэрээнд тусгагдаагүй асуудлаар оролцогч талууд Монгол улсын холбогдох хууль тогтоомжийг баримтална.

17. ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭНД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ

17.1. Оролцогч талууд хамтран ажиллах хорооны хурлын олонхийн шийдвэрийн үндсэн дээр гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж, хүчингүй болгож болно. нэмэлт, өөрчлөлтийг бичгээр байгуулж оролцогч талууд баталгаажуулсан байна.

18. ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭНД ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН АЛБАН ЁСНЫ ХАЯГ

Хэрэв “Дорнод ган хийц ХХК”-д хаяглах бол:

Хаяг: УБ хот, СХД, Баянхошуу 7-р хороо өөрийн байр

Утас: 99114923

Хэрэв “Улаанбаатар БҮК ХК”-д хаяглах бол:

Хаяг: УБ хот, БГД, 20-р хороо, Дунд голын эрэг, өөрийн байр

Утас: 70001182

Хэрэв “Мон цемент билдинг материалс ХХК ” ХХК-д хаяглах бол:

Хаяг: УБ хот, СБД, 1-р хороо, олимп, Тэнгэрийн цаг төв, 304 тоот

Утас: 99998350

Хэрэв “Монгол бетон дэрХХК”-д хаяглах бол:

Хаяг: УБ хот, БГД, 2-р хороо Рокмон билдинг 202 тоот

Утас: 99112193

Хэрэв “Энэрэл холдинг ХХК”-д хаяглах бол:

Хаяг: УБ хот, БГД, Энхтайвны өргөн төлөө, Кёкүшю цамхаг 1340 тоот

Утас: 99994590

Хэрэв “Пондрол”-д хаяглах бол:

Хаяг:

Утас:

Хэрэв “Боссло”-д хаяглах бол:

Хаяг:

Утас:

19. БУСАД ЗААЛТ

19.1. Энэхүү гэрээний хүрээнд явуулах, солилцох мэдээ, мэдэгдлийг бичгээр үйлдэнэ. Мэдэгдлийг доорх хаягийн дагуу холбогдох талын ажилтан буюу түүний төлөөлөгчид факс, баталгаат шуудан болон биеэр хүргэн өгнө. Мэдээ, мэдэгдлийг оролцогч талын эрх бүхий ажилтанд хүлээлгэн өгснөөр нөгөө тал хүлээн авсанд тооцно.

19.2. Гэрээг хууль зүйн хувьд адил хүчинтэй 9 хувь Монгол хэл дээр үйлдсэн бөгөөд талууд тус бүр 1 хувийг хадгалж, 1 хувийг захиалагчид өгөх, 1 хувийг нотариатчад хадгалуулна.


ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭНД ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН БАТАЛГААЖИЛТ

ОРОЛЦОГЧ ТАЛ БОЛОХ
“ДОРНОД ГАН ХИЙЦ”



ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ /М.ДАВААСҮРЭН/

ОРОЛЦОГЧ ТАЛ БОЛОХ
“УЛААНБААТАР БҮК”



ГҮЙЦЭГНЭХ ЗАХИРАЛ /Б.ЖАМБАЛ/

ОРОЛЦОГЧ ТАЛ БОЛОХ

“МОН ЦЕМЕНТ БИЛДИНГ МАТЕРИАЛС” ХХК -ийг төлөөлж:

ҮАЭ ЗАХИРАЛ /Д.МӨНХБАТ/

ОРОЛЦОГЧ ТАЛ БОЛОХ

“МОНГОЛ БЕТОН ДЭР” ХХК -ийг төлөөлж:

ТӨСЛИЙН УДИРДАГЧ /Х.ЧИНБОЛД/



ОРОЛЦОГЧ ТАЛБОЛОХ
“ЭНЭРЭЛ ХОЛДИНГ” ХХК -ийг төлөөлж:

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ /Б.ЭНХБААТАР/



ОРОЛЦОГЧ ТАЛБОЛОХ
“ПОНДРОЛ” ХХК -ийг төлөөлж:

.....
ЗАХИРАЛ

ОРОЛЦОГЧ ТАЛБОЛОХ
“БОССЛО” ХХК -ийг төлөөлж:

.....
ЗАХИРАЛ

